

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 5-Р СУРГУУЛЬ



ӨВЛӨХҮЙН УХААНД ХАМТДАА

Говьсүмбэр аймгийн 5-р сургуулийн “3-р ангийн секц”

З.Золзаяа, Н.Энхжаргал, М.Хандсүрэн, А.Оюунчимэг

2022 он

Гарчиг

Оршил	3
Сэдэв сонгосон үндэслэл	3
Онолын хэсэг	3-4
Сэдвийн судлагдсан байдал	4-6
Хамтын ажиллагаа	6-7
Судалгааны хэсэг	7-11
Дүгнэлт	12
Цаашид дэвшүүлэх санал	12
Ном зүй	13
Хавсралт	14-23

ОРШИЛ

Аливаа үндэстэн оршин тогтнохын эх үндэс нь эх хэл билээ. Эх хэлээрээ ярьж, уншиж, бичиж сурах нь бүх шинжлэх ухааны үндэс суурь болдог.

Эх хэлээ хэрхэн эзэмшүүлэх вэ? гэдэг асуудал боловсролын түүхэн хөгжлийн явцад хамгийн чухал сэдэв байсаар ирсэн.


Даяаршин хөгжиж байгаа өнөө үед хэрхэн ондоошиж үлдэх, монгол өв соёлоо нандигнан хадгалахын анхны алхам бол эх хэлний дархлаа юм. Энэхүү дархлааг хадгалан үлдэхийн тулд бид ахмад багш нараасаа суралцах, залуу дунд үеийнхэн хамтдаа хөгжих нь чухал юм.

Эх хэлээрээ уншуулж бичүүлж сургахад багш бидний оролцоо нэн чухал. Сургахын тулд судлах нь бидний үүрэг билээ. Шинжлэх ухаан техникийн үсрэнгүй хөгжил олон шинэ зүйлийг бий болгохын зэрэгцээ хэрэглээ дагасан олон олон гадаад үг хэллэг монгол хэлэнд минь холилдож байна. Үүнд анхаарлаа хандуулах нь боловсролын байгууллагын бодлого, багш бүхний сэтгэлд байх ёстой зүйл гэж үзлээ.

Сэдэв сонгосон үндэслэл:

Эх хэлээ эзэмшихийн эхний үйл нь уншиж сурах юм. Уншиж сурснаар хүний сурах үйл нээгддэг. Бага боловсролд тулгамдаж буй асуудал бол ойлгож унших чадварыг хөгжүүлэх. Бага боловсролын унших чадварын үнэлгээг /EGRA/-Г үндэсний түвшинд түүврийн аргаар зохион байгуулахад хамрагдсан сурагчдын 73%-нь эхэд тулгуурласан асуултад хариулсан даалгаврын гүйцэтгэл буюу “Уншаад ойлгох” даалгаврын гүйцэтгэл нь доогуур үнэлэгдсэн. Ойлгож унших чадварын суурь нь авиан дуудлага. Бид сургуульдаа 4 бүлэгт хичээл заадаг залуу, дунд, ахмад үеийн төлөөлөл. Бидний өмнө танхим, цахим хосолсон өвөрмөц нөхцөлд сурагчдаа уншуулж, бичүүлж сургах шаардлага тулгарсан. Энэ үед хамтдаа хэрхэн ажилласан ямар үр дүнд хүрснээ дүгнэн бичихээр шийдвэрлэлээ.

Монгол улсын гавьяат багш Б.Бүүдэд нь 1947 онд төрсөн. Бага ангийн багшаар тасралтгүй 54 жил ажиллажээ. Биднийг 1 дүгээр анги даан авч ажиллахад багш маань тэтгэвэрт гарсан ч сургуульдаа ажиллаж байсан. Б.Бүүдэд багшийн уншуулж сургадаг туршлага нь “Авиа, үсэг таниулахдаа авианы хэл, хэлэхийн онцлог, авианы задлаг, нийлэг аргаар заадаг. Авиаг хэлэхэд өгүүлэх эрхтэн хэрхэн оролцож байгааг нарийн ажиглуулж, зөв дуудуулж зүгшрүүлэхийг чухалчилдаг. Б.Бүүдэд багшийн анх ажиллаж байсан 60-аад оны дундуур авиа, үсгийг таниулахдаа “Авиан зүйн дуудлагыг” маш сайн заадаг байсан байна. Ингээд бид багаараа ахмад багштайгаа хамтран ажиллаж арга туршлагаас нь суралцсан.

Онолын хэсэг:

Тархи судлалын үүднээс авч үзвэл нялх хүүхэд эргэн тойронд өрнөж буй яриаг сонсох явцад тархи нь тухайн хэлний дүрэмд суралцаж, хожим уншиж сурах үйлд аажмаар бэлтгэгдэж байдаг. Сурагчид унших чадвар дадлыг хэдий сайн эзэмшвэл бичих чадварыг хөгжүүлэхэд төдий чинээ сайн нөлөөтэй байдаг. Цагаан толгойн үсэг тус бүрийн дүрс хэлбэрийг бүтээх зурлага, яаж бичих журам, бусад үсэгтэй холбон бичих журам зэрэг нь крилл бичигт зүүнээс баруун тийш нь хөндлөн бичиж, үсгийн ихэнх зурлагыг нар буруу эргүүлэн бичдэг өвөрмөц онцлогтой.

1. Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр, сурах бичигт хийсэн шинжилгээний тайлан, “Боловсролын чанарын шинэчлэл тайлан, БСШУЯ, Дэлхийн банк, 2018 он 58 тал
2. Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх үнэлэх зарим арга хэрэгсэл 10 тал

Уншуулж сургахын тухайд эхлээд зөв унших, зөв, хурдан унших, зөв хурдан, ойлгож унших, зөв, хурдан, ойлгож, бүтээлчээр унших аргуудыг анги ахих бүр нарийн шат дараатайгаар эзэмшүүлэх нь чухал.

Унших чадвар эзэмшсэн хүн судалж буй хичээлүүдийн агуулгыг эзэмшихээс гадна шаардлагатай мэдээллийг бусад эх сурвалжаас эрж олох, асуудалд өөр өөрийн байр сууринаас хандах, шүүн тунгаах чадвартай болдог.


Сэдвийн судлагдсан байдал

Зөв унших нь авиаг зөв дуудахаас эхэлнэ. Сурагч авиаг зөв дуудаж сурвал үгээ зөв холбон унших, үгээ хэлбэрийн хувьд таньсан бол ойлгох, үгийн утгыг мэдэх, хэрэглэхэд ач тустай. Үгийг хэрэглэх үед харилцаа бий болж, бүхэл бүтэн эхийн түвшинд унших, сэтгэх, хэрэглэх болно. Яриа гадагш дуу авиагаар илрэх ба дуу авиа нь яригч этгээдийн оюун бодол, сэтгэл хөдлөл, зоригийг агуулсан бие сэтгэлийн нарийн үйл ажиллагааны үр дүн болдог.

Үсгийн зөв дуудлагыг тайлж, үгэнд хөрвүүлж, утгыг танихыг унших гэнэ. Уншихдаа авиануудыг зөв дуудаж, тэдгээрийн нийлц болох үе, үгийг зөв хэлж, сольж гээлгүй, амьсгалаа зөв тохируулан уншихыг зөв унших гэнэ. Женкинс, Жевелл /1993/ нар уншлагын хурд ба ойлгох чадварын хоорондын хамааралд хүүхдийн нас хэрхэн холбогдож буйг судлахад уншлагын хурд ба ойлгох чадварын хоорондын хамаарлын коэффициент 1-р ангид 0.88 байснаа анги ахих тусам буурсаар 6-р ангид 0.6 болсон байна. Энэ нь хүүхдийн уншиж ойлгох чадварыг бага ангиас нь хөгжүүлэх нь чухал гэсэн дүгнэлтэд хүрчээ.


2018 онд БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ, ДЭЛХИЙН БАНК, БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН хамтарч “Боловсролын чанарын шинэчлэл” төслийг лаборатори сургуулиудад туршиж, 2019 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн.

EGRA Олон улсын бага боловсролын унших чадварын үнэлгээнд хамрагдсан манай улсын ЕБС-ийн I, II дугаар ангийн сурагчдын үр дүнг графикаас харахад II даалгавар буюу үгийг сонсоод эхэнд нь сонсогдож байгаа авиаг хэлэх, III даалгавар буюу бичсэн үсгүүдийг хараад авиаг дуудах, IV даалгавар буюу бичил эхийг уншаад ойлгосныг үнэлэх зэрэг даалгаврын гүйцэтгэл нэлээд доогуур байна.



Нэгдүгээр даалгавар буюу үсэг нэрлэх даалгаврын гүйцэтгэл 59.03 хувьтай атал үг сонсоод эхэнд нь ямар авиа сонсогдож байгааг хэлэх даалгаврын гүйцэтгэл 25.91 хувь, сонсоод ойлгох чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэл 59.4 хувь байхад уншаад ойлгох чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэл 27.06 байгаа нь асуудал юунд байгааг илтгэж байна.

1,2 дугаар ангийн хувьд эдгээр үзүүлэлт дараах байдалтай байжээ.



Туршилт судалгаа:

Зорилго: Үсэг таниулах, авиан дуудлага заах арга зүйд хамтдаа суралцана.

Зорилт: 1. Авиан дуудлага, заах арга зүйг ахмад багшаас суралцана.

2. 1 дүгээр ангийн суралцагсдын унших чадварын судалгааг авч дүгнэлт гаргана.

3. Авиан дуудлагаар заах арга зүйн хэрэгжилт, үр дүнг илрүүлнэ.

Монгол улсын гавьяат багш Б.Бүүдэд багшийн туршлага:



Бид 2019 онд 1 дүгээр анги даан авч ажиллахдаа зөвлөх, МУГБ Б.Бүүдэдээс “Авианы ерөнхий зүй тогтол”-ын талаар сургалт авч, хамтын хичээлийг 8 удаа заасан.

Мөн тухайн үеийн нөхцөлд байдлаас шалтгаалан цахим хичээл бэлдэх шаардлагатай болсон. 1-р ангийн сурагчдад үсгийн авиан дуудлага чухлаас гадна үсгийн зурлага нь ч мөн тэр хэмжээгээр чухал юм.


Авиа үсгийн цахим хичээл – 10

Унших болон дасгал ажиллуулах цахим хичээл – 8

Математикийн хичээл – 8 тус тус хамтран бэлдсэн.

Хөдөө алслагдмал байдаг, цахим орчинд суралцах боломжгүй суралцагсдаа 8 удаа цаасаар хичээл бэлтгэн хүргүүлж ажилласан.

2-р ангидаа сурагчдын унших чадварыг хөгжүүлэх чиглэлээр Уншлагын хурд нэмэгдүүлэх харааны дасгалыг тогтмол хийсэн. Мөн унших идэвх сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд самбар ашиглан урамшууллын ханыг босгосон.



Ойлгож унших чадварыг хөгжүүлэх хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон жижиг эх, гарын авлагыг сонгон уншуулах, ойлгосноо ярилцах зэрэг үйлүүдийг суралцагчдаар хийлгэж ажилласан нь үр дүнгээ өгч байна.



ДӨРӨВ СУДАЛГААНЫ ХЭСЭГ: А.Өнгөрсөн:Авиа зүйн дуудлагыг чухалчилдаг байсан.



Гавъяат багш Г.Лхаахүү багш анх үеэр заах “Цагаан толгой”-г зохиосон

Б.Одоо: Уншлага бол жирийн нэг үндсэн чадвар төдий биш, оюуны нарийн төвөгтэй үйл явц. Иймд зөв аргаар уншуулж , унших чадварыг хөгжүүлэхийг зорьж байна.

В.Ирээдүй: Бага ангийн багш бүр хэл яриаг хөгжүүлэх хамгийн чухал арга болох хурдан ойлгож унших чадварыг эзэмшүүлэхэд зөв арга зүйгээр чиглүүлэх явдал юм.


Судалгааны зорилт:Авиа үсэг таниулахдаа багш авианы хэл, хэлэхийн онцлогийг анхаарах

2019 оны 1 дүгээр ангийн 4 бүлгийн хувьд:

2019 оны 9дүгээр сарын 1ээс 12дугаар сарын 22 ны хүртэл танхимаар 85 хоног, 2020 оны 2-р сарын 3 аас теле хичээлээр 75 хоног хичээллэсэн үр дүнг 2 дугаар ангийн 171 сурагчийг оношлоход:

1. Дараах цагаан толгойн үсгүүдийн авиаг зөв тод хэлээрэй. Мэдэхгүй авиа үсэг байвал орхиод, цааш үргэлжлүүлэн хэлээрэй.


н	а	с	о	ы	ф	ш	п	в	д	к
у	я	м	и	р	з	т	ё	щ	г	й
б	ч	е	ж	ө	э	х	л	ю	ц	ү





Үгийг уншихад :

3. Үгсийг тод, зөв уншихыг хичээгээрэй. Мөрийн дагуу арагш уншаарай. Хэрвээ мэдэхгүй үг гарвал орхиж, цааш үргэлжлүүлээрэй.


мөр	А	Б	В	Г	Д
1	жам	бар	ямаа	яам	карт
2	зар	тал	ёс	соёо	Пүрэв
3	урц	хад	ес	хөөв	форм
4	ач	гол	юм	юу	борц
5	жараахай	бөмбөг	мягмар	яаралтай	фабрик
6	зарлал	торой	ёроол	соёолон	кино театр
7	цуурай	дудран	ерөөл	үеүд	олимп
8	ачаалал	Гонгор	Юндэн	аюултай	Щедрин




Бичих чадвар:



Оношлогооны үр дүнд анализ хийхэд цахим, танхим хосолсон сургалтын үр дүн, дан танхимаар хичээллэдэг үеийн үр дүнгээс харьцангуй доогуур байсан. Дөнгөж уншиж бичиж сурч байгаа хүүхдүүд харьцангуй өөр төвшнөөс гараагаа эхэлж байгаа нь тулгамдсан асуудал болж байлаа. 2019 ба 2021 оны 1-р ангиудын Үсгийн авиан дуудлагын харьцуулалт:




2019 онд төслийн хүрээнд 1 дүгээр ангиудад “Унших чадварын модуль туршсан. Туршилтын жилийн 1 дүгээр ангиудын гүйцэтгэл өндөр байна. Гэтэл 2021 оны 1 дүгээр ангийн багш нарын заах арга зүй дутмаг байна..



Үгийг зөв унших, танил болон зохиомол үгийг унших чадварын судалгаанаас харахад 2019 , 2020, 2021 оны гүйцэтгэл 2-8 хувиар ахисан үзүүлэлт гарч байна.


Зөв хурдан унших чадварын судалгаа:



1 минутанд уншсан үгийн тооноос, буруу уншсан үгийн тоог хасаж уншлагын тоог гаргасан.


2019 оноос 2021 оны хооронд 3-5 хувь ахисан байна.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын лаборатори 5 дугаар сургуулийн 2017 оноос 2021 оны 2 дугаар ангийн 18 бүлгийн 520 сурагчдаас “Унших чадварын судалгаа “ авсан дүгнэлт Ойлгож унших чадварын суурь болж байгаа эсэхийг илрүүлэх



2019 оноос 2021 оны гүйцэтгэл нь 20 орчим хувиар ахисан байна.

Говьсүмбэр аймгийн 35 бага ангийн багшийн хүрээнд онлайнаар google form ашиглан судалгаа авсан. Судалгааны зорилго нь үсгийг таниулахдаа авиа зүйн дуудлага, битүү үеэс авиаг таниулж байгаа эсэх, багш нарын заах аргазүйн чадварыг илрүүлэхийг зорьсон.




Графикаас харахад: 2019 онд лаборатори сургуулиудад “Унших чадварын модуль туршсан тул авиан зүйн дуудлага, битүү үеэр таниулах заах арга зүй хэрэгжсэн байна. 2017, 2018, 2020, 2021 оны 1 дүгээр ангийн багш нар “Авиа зүйн дуудлага”-ын заах арга зүйд суралцаагүй байна.



Эцэг эхийн хандлага

Эцэг эхийн асуумжийн зорилго: Цахим, танхим хосолсон сургалтын нөхцөлд эцэг эхийн оролцоо, хандлага хэрхэн өөрчлөгдсөн байна гэдгийг илрүүлэх




Асуумжийн дүгнэлт: Уншуулж чадна гэж хариулсан эцэг эх 45.5 %-тай байгаа нь цахим хичээл орсноор эцэг эхийн оролцоо нэмэгдсэн эерэг хандлага байгаад талархаж байна.

Асуумжийн зорилго: Ном унших сонирхолтой сурагчдын тоог илрүүлэх, номонд дурлуулахад анхаарах



Асуумжийн дүгнэлт: Гэртээ ном уншдаг хүүхэд 80.4%-тай байгаа нь цаашид эцэг эхчүүдийг гэртээ номын сантай болгоход чиглүүлэх, хүүхдүүд номонд дурлах хандлага байгаа нь ангийн номын сангийн ажил ач холбогдол өгч байна гэж дүгнэлээ.

Асуумжийн зорилго: Эцэг эхчүүд хүүхдээ уншихын хувьд ямар чадвар эзэмшүүлэхийг илүүд үзэж байгааг илрүүлэх



Асуумжийн дүгнэлт: Ойлгож унших чадварыг сонгосон эцэг эх 89.9 % байгаа нь унших, ойлгох гэсэн хоёр үйлийг чухалчилж буйг илтгэлээ. Иймээс сурагчдыг зөв, хурдан, ойлгож уншуулахад багш бид анхаарлаа хандуулах нь зөв гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Асуумжийн зорилго: Уншуулж бичүүлж сургахад эцэг эхчүүдэд тулгардаг бэрхшээлийг илрүүлэх, ямар зөвлөмж өгч ажиллахаа тодруулах

Асуумжийн дүгнэлт: Цаг хугацаа их шаарддаг, бүх зүйл л хүндрэлтэй, заах арга дутмаг, удаан уншиж тогтвортой суудаггүй, үсгээ андуурдаг, багшгүйгээр уншуулж бичүүлж чадаагүй, ямар нэг бэрхшээл гараагүй, үсэглэх, буруу унших, тааж унших, тодорхой цаг, арга зүйгээр зөв бичих зэргийг оновчтой зааж чаддаггүй, дуудлагын арга зүй дутмаг, буруу зааж өгөх, хангалттай цаг гарахгүй байсан. Хүүхэд үеийнхэнтэйгээ хөгжилдөж даган дуурайж суралцвал сайн гэх мэт хариултууд зонхилж байв. Уншуулж бичүүлж сургах нарийн дэс дараалалтай ажлыг нягт нямбай төлөвлөж эцэг эхчүүдэд зөвлөн туслах ажлыг цахимаар бага цагт ихийг сургах замаар хэрэгжүүлэх нь зөв гэж дүгнэлээ.

Асуумж 5: Та хүүхдээ уншуулж бичүүлж сургахад юуг анхаардаг вэ?

Асуумжийн зорилго: Багш бидний зорьж байгаа зорилго эцэг эхчүүдийн хүсэж байгаа зорилготой хэр нийцэж байдгийг илрүүлэх

Асуумжийн дүгнэлт: Өдөр тутам тасралтгүй уншуулахыг хичээдэг, зодчихгүйг хичээдэг, багшийн дэмжлэг их хэрэгтэй, ойлгож хамтран цуг бичих, Цэвэр нямбай бичихэд анхаарах, танхимын хичээл маш чухал, удаан ч гэсэн ойлгож уншиж бичиж байвал болоо гэж боддог, ойлгуулж, тайлбарлаж ярилцдаг гэсэн хариултууд зонхилж байв. Үүнээс үзэхэд удаан ч гэсэн ойлгон уншиж бичиж байвал болоо гэсэн эцэг эхийн хандлагыг өөрчилж хамтран ажиллах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Дүгнэлт

- 1960,1970-аад оны үеийн бага ангийн багш нараас авиан дуудлага заах аргагүй, битүү үеэс таниулах заах аргазүйд суралцах шаардлагатай байна.
- Жил бүрийн 1 дүгээр ангийн багш нар авиан дуудлага, битүү үеэс таниулах арга зүйд суралцаагүй байна.2020, 2021 онд 1 дүгээр анги даасан багш нар авиа үсгийн дуудлагыг хуучин аргаараа зааж байгааг бидний судалгаа илрүүлсэн.
- Ахмад багш нартайгаа хамтарч, тэдний аргазүйгээс суралцахаас гадна хамгийн чухал зүйл бол авиан зүйн дуудлагыг нь өвлөж үлдэх хэрэгтэй байна.

Цаашид дэвшүүлэх санал:

- Багш бүр дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд гаргасан “ Бага ангийн сурагчдын унших чадварыг үнэлэх зарим арга, хэрэгсэл”гарын авлагыг судалж турших шаардлагатай байна.
- 2020-2021 онд 1-р анги даасан багш нар авиа үсгийн дуудлагыг хуучин аргаараа зааж байгааг бидний судалгаа илрүүлсэн. Иймд 1-р анги даан авч ажиллах багш бүрийг намар хичээл эхлэхээс өмнө” Авиан зүйн дуудлагад” суралцуулах нь зүйтэй гэж үзлээ.
- Бага ангийн сурагчдыг ойлгож унших чадварт сайн сургах нь нэн тэргүүний зорилго болж байгаад анхаарах





НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ





- Г.Лхаахүү “Цагаан толгой”

- С.Батхуяг, Б.Төртогтох, Н.Цогзолмаа “Боловсрол судлалын судалгааны арга техник. УБ. 2015
- Сургалтын цөм хөтөлбөр
- Суралцахуйн зорилт
- Орчин цагийн монгол хэлний онол-аргазүйн зөвлөмж
- Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх үнэлэх, зарим арга хэрэгсэл УБ. 2018
- Ч.Алтанцэцэг, Ц.Отгонбаяр “Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх” УБ. 2018

Хавсралт: Судалгааг хавсаргав.

2014 оноос 2019 оны хичээлийн жилд даан авч ажилласан ангийн сурагчдын уншлагыг анализ хийсэн байдал:








Хүүхдийг хурдан, зөв, ойлгон уншуулахад урамшууллын арга чухал үүрэгтэй.








Унших чадвар сайн хүүхэд бичих чадвар нь сайн байдаг.



Цэвэр бичгийн анализ				
№	Суралчийн нэр	11-р сарын 13	11-р сарын 14	11-р сарын 15
1	Алтан	13	13	13
2	Алтан	13	13	13
3	Алтан	13	13	13
4	Алтан	13	13	13
5	Алтан	13	13	13
6	Алтан	13	13	13
7	Алтан	13	13	13
8	Алтан	13	13	13
9	Алтан	13	13	13
10	Алтан	13	13	13
11	Алтан	13	13	13
12	Алтан	13	13	13
13	Алтан	13	13	13
14	Алтан	13	13	13
15	Алтан	13	13	13
16	Алтан	13	13	13
17	Алтан	13	13	13
18	Алтан	13	13	13
19	Алтан	13	13	13
20	Алтан	13	13	13
21	Алтан	13	13	13
22	Алтан	13	13	13
23	Алтан	13	13	13
24	Алтан	13	13	13
25	Алтан	13	13	13
26	Алтан	13	13	13
27	Алтан	13	13	13
28	Алтан	13	13	13
29	Алтан	13	13	13
30	Алтан	13	13	13
31	Алтан	13	13	13
32	Алтан	13	13	13
33	Алтан	13	13	13
34	Алтан	13	13	13
35	Алтан	13	13	13
36	Алтан	13	13	13
37	Алтан	13	13	13
38	Алтан	13	13	13
39	Алтан	13	13	13
40	Алтан	13	13	13
41	Алтан	13	13	13
42	Алтан	13	13	13
43	Алтан	13	13	13
44	Алтан	13	13	13
45	Алтан	13	13	13
46	Алтан	13	13	13
47	Алтан	13	13	13
48	Алтан	13	13	13
49	Алтан	13	13	13
50	Алтан	13	13	13

Цэвэр бичгийн анализ				
№	Суралчийн нэр	11-р сарын 13	11-р сарын 14	11-р сарын 15
1	Алтан	13	13	13
2	Алтан	13	13	13
3	Алтан	13	13	13
4	Алтан	13	13	13
5	Алтан	13	13	13
6	Алтан	13	13	13
7	Алтан	13	13	13
8	Алтан	13	13	13
9	Алтан	13	13	13
10	Алтан	13	13	13
11	Алтан	13	13	13
12	Алтан	13	13	13
13	Алтан	13	13	13
14	Алтан	13	13	13
15	Алтан	13	13	13
16	Алтан	13	13	13
17	Алтан	13	13	13
18	Алтан	13	13	13
19	Алтан	13	13	13
20	Алтан	13	13	13
21	Алтан	13	13	13
22	Алтан	13	13	13
23	Алтан	13	13	13
24	Алтан	13	13	13
25	Алтан	13	13	13
26	Алтан	13	13	13
27	Алтан	13	13	13
28	Алтан	13	13	13
29	Алтан	13	13	13
30	Алтан	13	13	13
31	Алтан	13	13	13
32	Алтан	13	13	13
33	Алтан	13	13	13
34	Алтан	13	13	13
35	Алтан	13	13	13
36	Алтан	13	13	13
37	Алтан	13	13	13
38	Алтан	13	13	13
39	Алтан	13	13	13
40	Алтан	13	13	13
41	Алтан	13	13	13
42	Алтан	13	13	13
43	Алтан	13	13	13
44	Алтан	13	13	13
45	Алтан	13	13	13
46	Алтан	13	13	13
47	Алтан	13	13	13
48	Алтан	13	13	13
49	Алтан	13	13	13
50	Алтан	13	13	13



Түүврийн аргаар 1-р ангийн 4 бүлгээс эгшиг болон гийгүүлэгч авиаг зөв дуудаж байгаа эсэх тал дээр анализ хийлээ.

ГСА 5-р сургуулийн 1-р ангиуд														
					2021 - 2022 он									
№	Сурагчдын нэрс	Эг	ши	Ур	уу	лы	Хэлний гийгүүлэгч		Ав	са	Ав	ах	Ху	вь

				Урдурх т,л,ш,р,с	Хойгуурх н,г,х			
		7	3	5	3			
1	Ану-Үжин	7	1	3	0	11	18	61%
2	Сайхан билэг	7	2	4	0	13	18	72%
3	Мөнхбаатар	7	2	4	0	13	18	72%
4	Итгэл	7	1	4	0	12	18	67%
5	Отгонжаргал	7	1	4	0	12	18	67%
6	Анар	7	1	4	0	12	18	67%
7	Номин	6	1	4	0	11	18	61%
8	Хатанзаяа	7	2	4	0	13	18	72%
9	Сондор	7	1	4	0	12	18	67%
10	Ананд	6	1	4	0	11	18	61%
11	Сүлд	6	1	3	0	10	18	56%
12	Үжин	6	2	3	0	11	18	61%
13	Монголжин	7	1	4	0	12	18	67%
14	Дэлгэрмаа	6	1	3	0	10	18	56%
15	Азбаяр	7	1	4	0	12	18	67%
16	Баясгалан	6	1	4	0	11	18	61%
	Авсан оноо	106	20	60	0	186		
	Авах оноо	112	48	80	48		288	
	Хувь	95	42	75	0			65
1	Гандорж	7	2	4	2	15	18	83%
2	Эрдэнэзаяа	7	2	1	1	11	18	61%
3	Намуун	7	2	4	0	13	18	72%
4	Гэгээннаран	7	2	5	1	15	18	83%

5	Буян-Эрдэнэ	7	1	4	0	12	18	67%
6	Энгүүн-Уянга	7	1	4	1	13	18	72%
7	Мөнхцэлмүүн	7	1	4	1	13	18	72%
8	Халиун	7	2	4	1	14	18	78%
9	О.Намуун	7	1	4	0	12	18	67%
10	Өсөхбаяр	7	1	4	0	12	18	67%
11	Чинхүслэн	7	2	4	0	13	18	72%
12	Уран-Үжин	7	1	4	0	12	18	67%
13	Дашдэмбэрэл	7	1	4	0	12	18	67%
14	Төрмандах	7	2	4	0	13	18	72%
15	Сувдмаа	5	2	3	0	10	18	56%
	Авсан оноо	103	23	57	7	190		
	Авах оноо	105	45	75	45		270	
	Хувь	98	51	76	16			70%
1	Энхжин	6	1	4	0	11	18	61%
2	Чингүүнжав	7	1	4	0	12	18	67%
3	Номингоо	7	2	4	0	13	18	72%
4	Энхриймаа	7	1	4	0	12	18	67%
5	Цолмонтуяа	7	1	4	0	12	18	67%
6	Далай	7	2	4	2	15	18	83%
7	Өрнөх	7	2	4	1	14	18	78%
8	Маргад	7	1	4	0	12	18	67%
9	Номуунгоо	7	2	4	0	13	18	72%
10	Энхсаран	7	2	4	1	14	18	78%
	Авсан оноо	69	15	40	4	128		
	Авах оноо	70	30	50	30		180	

	Хувь	99	50	80	13			71%
1	Бүжинлхам	7	1	4	0	12	18	67%
2	Гэгээнхүслэн	7	1	4	0	12	18	67%
3	Аминжаргал	7	1	4	0	12	18	67%
4	Тэмүлэн	7	1	4	0	12	18	67%
5	Гоосаран	7	1	4	0	12	18	67%
6	Ганөлзий	7	2	5	3	17	18	94%
7	Ачита	7	1	4	0	12	18	67%
8	Хасар	7	1	4	0	12	18	67%
	Авсан оноо	56	9	33	3	101		
	Авах оноо	56	24	40	24		144	
	Хувь	100	38	83	13			70%

Багш нараас авсан цахим судалгаанаас түүвэрлэв:

№	Та аль аймаг хотод амьдардаг вэ?	Та одоо хэддүгээр ангид хичээл заадаг вэ?	Та "Ц" үсгийн авиан дуудлагын зөвийг сонгоорой.	Дараах авиан дуудлагат тохирох үсгийг нэрлээрэй. " Эр чанга, хэлний хойгдох амны хөндийн	Та үсэг таниулахдаа задгай үеэр таниулсан уу? Битүү үеэр	Та авиа үсгээ таниулсан туршлагаасаа хуваалцана уу?
1	Говьсүмбэр	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Битүү	Үгийн төгсгөлөөс нь гийгүүлэгчээ таниулдаг.
2	Дорноговь	5-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Задгай	Битүү -задгай

3	Говьсүмбэр	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Битүү	Үгийн төгсгөлөөсөө эхлэн таниулан авиан дуудлагаа нэрлүүлэх
4	Багахангайдүүрэг	2-р анги	Шуугиант буюу анир илүү оролцож бүтэх гийгүүлэгч, хажуугийн шүргэх	А	Задгай	Дуурайлган хэлүүлж уншуулах
5	Говьсүмбэр	2-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	Уй	Задгай	Нүдлэн тогтоох арга
6	Говьсүмбэр аймаг	1-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Битүү	Авиа үсгийг хэрхэн дуудаж хэлж байгаа бичлэгийг сурагчдад үзүүлж дагуулж хэлүүлж байгаа
7	УБ хот	2-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	А	Задгай	Авиан дуудлагад илүү анхаарч заасан
8	УБ	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	Уй	Задгай	Сурах бичгийн дагуу
9	УБ	3-р анги	Шуугиант буюу анир илүү оролцож бүтэх гийгүүлэгч, ерийн шүргэх	У	Битүү	Битүү үеэр таниулдаг

10	Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сум	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	Уй	Задгай	Зураг харж өгүүлбэр зохиолгох дармал үсэг бүтээлгэх төстэй зүйлийг ярилцах задгай үе уншуулах агаарт бичүүлэх давхарлан бичүүлэх гэх мэт
11	Говьсүмбэр	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Битүү	Үеийн хүснэгтээ битүү ба задгай үеэр харьцуулан ажиглуулж зааж нүдлүүлсэн.Үсэг таниулахдаа авиан дуудлагыг зөв дуудуулж сургахыг хичээсэн. Үгийн адагт орсон гийгүүлэгч авиаг маш зөв дуудахыг зорьсон.
12	Дорноговь	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Битүү	Аливаа зүйлтэй зүйрлэн тогтоолгож таниулдаг
13	Говьсүмбэр	2-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	Уй	Задгай	Үе л сайн нүдлүүлсэн
14	Дорнод	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	О	Задгай	Зурагнаас өгүүлбэр зохиолгоод, өгүүлбэрээс үг сонгоод, авиагаа таниулдаг.
15	tow	1-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Задгай	.
16	Дорноговь Даланжаргалан	4-р анги	Шуугиант буюу анир илүү оролцож бүтэх гийгүүлэгч, ерийн шүргэх	У	Битүү	Авианы задлаг аргыг хэрэглэдэг

17	Говьсүмбэр	2-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, чичрэн шүргэх	У	Задгай	Задгай үеийн аргаар
18	Говьсүмбэр	4-р анги	Шуугиант буюу анир илүү оролцож бүтэх гийгүүлэгч, хажуугийн шүргэх	У	Битүү	Задлаг нийлэг арга
19	Улаанбаатар	3-р анги	Шуугиант буюу анир илүү оролцож бүтэх гийгүүлэгч, ерийн шүргэх	О	Задгай	Одоохондoo 1 дүгээр ангид үсэг таниулаагүй байгаа
20	Говьсүмбэр	5-р анги	Шуугиант буюу анир илүү оролцож бүтэх гийгүүлэгч, ерийн шүргэх	О	Задгай	Залгай үе нүдoүүoх
21	Говьсүмбэр	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Задгай	Битүү задгай үеийг хослуулан авиа үсгээ таниулсан.
22	Говьсүмбэр	3-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Битүү	Үсгээ таниулахдаа үгийн төгсгөлд орсноор нь заасан.
23	Говьсүмбэр	2-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	О	Задгай	Авиан дуудлагыг зөв дуудаж сургахад хүүхэд хурдан холбож уншиж сурсан

24	Говьсүмбэр	2-р анги	Шуугиант буюу анир илүү оролцож бүтэх гийгүүлэгч, ерийн шүргэх	У	Задгай	Авиа үсгээ багш өөрөө эхэлж хэлээд хүүхэд бүрээр даган дууриалгаж хэлүүлсэн
25	говьсүмбэр	5-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, чичрэн шүргэх	У	Битүү	олон үетэй үг сайн уншуулах
26	Дундговь	1-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Задгай	Авиа үсгийн ялгааг таниулахаас эхэлдэг
27	Дундговь аймаг	2-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	У	Задгай	ойрын жилүүдэд авиа үсэг таниулсангүй
28	Говьсүмбэр	5-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	А	Задгай	Авиа үсгээ таниулахдаа хамгийн түрүүнд зөв дуудуулж сургах нь чухал гэж боддог.
29	Говьсүмбэр аймаг	2-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, чичрэн шүргэх	У	Задгай	Авиан дуудлагаар таниулсан
30	Говьсүмбэр	1-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, чичрэн шүргэх	У	Битүү	Сурагчдад авиа таниулахдаа ихэвчлэн битүү үетэй үг сонгоод, давтан хэлүүлдэг. Дараа нь тухайн үгэнд өөрсдийн мэдэхгүй ямар авиа сонсогдож байгааг хэлүүлнэ. Тухайн авиа үгийн хаана сонсогдож байгааг асууна. Уг авиаг хэлэхэд амны ангайлт, уруулын

						хөдөлгөөн яаж харагдаж байгааг ажиглуулна.Битүү үеэс таниулсаны дараагаар задгай үетэй үгийг ашигладаг.
31	Говьсүмбэр	4-р анги	Шуугиант буюу анир оролцож бүтэх гийгүүлэгч, хамжин шүргэх	А	Задгай	Задгай үеэр таниулсан

